

2026 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-01-08

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 01 дүгээр сарын 14-ний “Лхагва” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Нийслэлийн хэмжээнд 2026 оны 01 дүгээр сараас эхлэн нөөцийн мах борлуулах ажлыг зохион байгуулах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
2.	Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой ажлын саналыг боловсруулж танилцуулах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
3.	Байгууллагууд ажилтан, албан хаагчид болон ерөнхий боловсролын сурагчдыг эрүүл мэндийн үзлэг, цагаан хорхойны шинжилгээ өгөх ажлыг зохион байгуулах.	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Боловсролын хэлтэс, Боловсролын байгууллагууд, Эрүүл мэндийн төв, Нийт байгууллагууд
4.	Одоо байгаа бүтэц, орон тоог нэмэгдүүлэхгүйгээр албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх боломжийг судалж, санал танилцуулах.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
5.	2026 оны Байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах, бэлтгэл ажлыг хангах	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийт байгууллагууд
6.	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр бий болгох чиглэлээр судалгаанд үндэслэн төлөвлөгөө гаргах, танилцуулах	Засаг даргын орлогч, ХСТНААХ, ХХҮГ, ЖДҮДТ, Хороод
7.	Эрүүл мэндийн төвийн нөөц эх үүсвэрийг холбох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Эрүүл мэндийн төв
8.	Дүүрэгт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч ажиллуулах санхүүжилтийн гэрээний төслийг бэлтгэх, байгуулах	Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв
9.	Эрүүл мэндийн төвийн сүрлэн байшинг сувиллаар ашиглах боломж нөхцөлийг судлах, танилцуулах	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв
10.	Эрүүл мэндийн төвийн В1 давхрын усанд автах асуудлыг мэргэжлийн инженер, холбогдох албан тушаалтанд танилцуулах,	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Эрүүл мэндийн төв

	шийдвэрлүүлэх	
11.	Өнгөрсөн онд зассан засмал замд үүссэн хагарал, цуурлыг гүйцэтгэгч байгууллагаар засвар үйлчилгээг хийлгэх	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
12.	Дээврийн засварын ажлуудыг нэгдсэн зургаар хийх 2 дугаар хорооны ижил загвартай байрнуудын дээврийн засварын нэг маягийн зурагтай болгох	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
13.	ХАСХОМ гаргах албан тушаалтнууд 2026.01.31 өдрийн дотор ХАСХОМ мэдүүлэх	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Эрх бүхий албан тушаалтнууд
14.	Гадна талбайн лед дэлгэцийг байнгын ашиглалтад оруулах, дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалт, ААНБ-ын үйл ажиллагааг сурталчлах	Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
15.	Цэргийн бүртгэлийн ажлыг эрчимжүүлэх, бүртгэлд хамрагдах чиглэлээр олон нийтэд сурталчлах	Цэргийн штаб, Хороод
16.	Суурьшлын бүсэд байгаа хар цасыг төвөөс гаргах, цэвэрлэх	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
17.	Дүүргийн ойролцоо хэрэгжиж буй төслүүдийн талаар мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулах	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
18.	Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын төсөл"-ийн бүтээн байгуулалттай холбоотой мэдээлэл солилцох уулзалт зохион байгуулах	Засаг даргын орлогч, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ